

**БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2023 оны 06 дугаар сарын 06

Рашаант

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО:УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.							
/"Алсын хараа -2050" зорилт 5.3,"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 5.3, "МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.1,Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/							
Зорилт 1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.							
1.1	Тоон гарын үсэг олгох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь	34,1	60	2023 оны 1 дүгээр сараас 6 сарын 06-ны өдрийн байдлаар цахим үнэмлэхэнд 13431, киоскоор 1219 тоон гарын үсэг олгож, нийт олголт 14650 болсноор 58,03 хувьтай байна.	58,3
1.2	Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлж, шинэчилсэн загвар бүхий бэлдцэд бичилт хийх, хэвлэх	1.530,1 сая.төг	Шинэчилсэн загвараар иргэний үнэмлэх олгосон хувь	1	10	Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлж, шинэчилсэн загвар бүхий бэлдцээр бичилт хийгдсэн 1803 иргэний үнэмлэхийг бүртгэж, баталгаажуулан иргэдэд олгоод байна.	3,04
1.3	Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шинэчлэн боловсруулах шаардлагатай дүрэм, журмын төсөлд санал хүргүүлэх	-	Эрх зүйн актын төсөлд санал хүргүүлсэн тоо	5	4	Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ирүүлсэн "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай" хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг	100

						<p>түүнийг дагалдуулан боловсруулсан бусад 3 хуулийн төсөлд санал хүргүүлж ажилласан.</p> <p>Мөн “ePRS-II” системд нэмэлт өөрчлөлт оруулах” талаар 9 саналыг, нийт 14 саналыг edkhourungu@burtgel.gov.mn хаягаар 2023 оны 05 дугаар сарын 10-нд хүргүүлсэн байна.</p>	
1.4	<p>Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу иргэдийн хаягийн өөрчлөлтийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд өөрчлөх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах</p>	-	<p>Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу иргэдийн хаяг шинэчлэгдсэн хувь</p>	30	100	<p>Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газраас 1, 2, 3, 4, 5, 6, 7, 9 дүгээр багуудын шинэ хуучин хаягийн судалгааг гаргуулан авч Иргэний улсын бүртгэлийн газарт мэдээллийг файлаар хүргүүлсэн. Харин шинээр баригдсан барилга, орон сууцны хаягийг газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газраас албан тоотоор авч санд тусгуулан ажиллаж байна.Эд хөрөнгийн бүртгэлийн хаяг Иргэний улсын бүртгэлийн санд тусгагдсантай холбогдуулан иргэд шилжилт хөдөлгөөний бүртгэлээр хаягаа шинэчилж шилжүүлж байна. 2023 оны 05 дугаар сарын байдлаар 481 том хүн түүнийг дагаж 376 хүүхэд шилжилт хөдөлгөөний бүртгэл</p>	50 хувь

						хийлгэж, хаягаа шинэчилсэн байна.	
1.5	Бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх	-	Улсын бүртгэлийн цахим машинаар үзүүлсэн үйлчилгээний тоо	4480	5000	2023 онд EMONGOLIA-гаар 16 үндэсний энгийн гадаад паспорт, 1 иргэний үнэмлэх захиалагдаж иргэнд олгогдсон байна. Харин иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл 5 дугаар сарын байдлаар EMONGOLIA – аар 14 хүсэлт илгээгдэж, 2 бүртгэл баталгаажиж, 12 бүртгэлийг бүртгэхээс татгалзсан байна. Хэлтсийн үйлчилгээний танхим дахь киоск машинаас нийт 1828 үйлчилгээ авсан байна.	36,56 хувь
Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмж, түргэн шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.							
2.1	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	Бүртгэлийн үйлчилгээ авах хүсэлтийн шийдвэрлэсэн хувь	100	100	-Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2023 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр нийт 10256 бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэн, баталгаажуулсан байна. - Тайлант хугацаанд буюу 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрөөс 2023 оны 05 сарын 25-ны байдлаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт 3837 мэдүүлэг хүлээн авч, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн байна. Үүнээс Анхны бүртгэл 290, эрх шилжсэн бүртгэл 458,	100

						<p>барьцааны эрхийн бүртгэл 2656, лавлагаа, хуулбар 124, эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт орсон бүртгэл 245, хувийн хэрэг хаах бүртгэл 51 бүртгэл бүртгэгдсэн байна.</p> <p>- Тайлант хугацаанд буюу 2022.11.26-ны өдрөөс 2023.05.25 өдрийг хүртэл хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр нийт 373 бүртгэл хөтлөсөн. Үүнд: шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж 97, шинэчилсэн бүртгэл 6, татан буугдсан 4, мэдээлэлд оруулсан өөрчлөлт 188, лавлагаа 13, хуулбар 13, тамга, тэмдгийн бүртгэл 16, бүртгэлээс хасахтай холбоотой хүсэлт 30, төрийн бус байгууллагын тайлан 6 зэрэг бүртгэлийг түргэн шуурхай үзүүлсэн байна.</p>	
2.2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх ажлыг үе шаттайгаар хийх ажлыг үргэлжлүүлэх	-	-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд зөрүүтэй орсон, алдаатай орсон мэдээллийг засч оруулсан тоо;	630	400	<p>1. ЭХЭУБГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 6/277 дугаарт албан бичгийн дагуу 17 хувийн хэргийг цахим санд тулган шалгаж, завсар өөрчлөлтийг хийж, тайланг “Илтгэх хуудас”-аар 2023 оны 01 сарын 11-ний өдөр edkhourung@burtgel.gov.mn хаяг руу илгээсэн болно.</p> <p>2. ЭХЭУБГ-ын даргын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 5/1854 дугаарт албан бичгээр ирүүлсэн “Хувийн хэрэг хаах” үйлчилгээг ePRS системээр хүлээн авч боловсруулалт</p>	100 хувь

					<p>хийсэн боловч өмчлөгчийн төлөв өөрчлөгдөөгүй “Өмчилсэн” төлөвтэй хэвээр харагдаж байгаа гэх 21 хувийн хэргийг цахим санд шалгаж, засвар өөрчлөлтийг хийсэн. Уг албан бичгийн хавсралтаар жагсаалтаар ирүүлсэн 36 хувийн хэргээс гадна УБЕГ-ын даргын 2021, 2022 оны тушаалаар “Хувийн хэрэг хаах” бүртгэл хийгдсэн 74 бүртгэл, нийт 110 бүртгэлийг тулган шалгаж, холбогдох өөрчлөлтийг хийж, тайланг e.suvderdene@burtgel.gov.mn хаягаар илгээж тайлагнасан болно.</p> <p>3.УБЕГ-ын ХШГ-ын хяналтын улсын байцаагчийн 1500 дугаарт дүгнэлтээр, хэлтсийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр, мөн ЭХЭУГ-аас ирүүлсэн тухайн бүрт нь цахим санд засаж, дахин цахимжуулах арга хэмжээг тухай бүрт нь авч байна. Энэ ажлын хүрээнд өнөөдрийн байдлаар цахим санд 145 хувийн хэрэг, бүртгэлийн мэдээллийг засаж, дахин цахимжуулсан байна.</p> <p>4.ЭХЭУБГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 5/4053 дугаарт албан бичгийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан /ePRS/-д гэр бүлийн</p>	
--	--	--	--	--	--	--

						хэрэгцээний зориулалттай өмчлөлийн газрын зориулалт “Ашигласан” гэсэн зориулалтаар бүртгэгдсэн гэх 2117 хувийн хэрэг, “Эзэмших” гэсэн төлөвтэйгээр бүртгэгдсэн гэх 113 хувийн хэрэг, нийт 2230 хувийн хэргийн цахим бүртгэлийг шалган засвар өөрчлөлтийг хийж, тайланг хэлтсийн даргын гарын үсгээр албажуулан хуулийн хугацаанд нь багтаан edkhourungu@burtgel.gov.mn , e.suvderdene@burtgel.gov.mn хаяг руу илгээж тайлагнав.	
2.3	Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх	-	-хүсэлтийг шийдвэрлэсэн хувь -Эрхийн улсын бүртгэлийг түтгэлзүүлсэн хувь	100 100	100 100	Иргэний бүртгэлийн чиглэлээр: 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 3796 лавлагаа олгосноос иргэнд 1692, албан хэрэгцээнд 1132, албан тоотоор 496 лавлагааг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан, мэдээлэл удирдах системд шалган, шаардлагатай тохиолдолд иргэний баримтын архиваас эх нотлох баримтыг татан авч тулгаж иргэдэд лавлагаа олгосон байна. -Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр: Хуулийн этгээдийн лавлагаа 18, үүнээс: иргэн, хуулийн этгээдэд 13, төрийн байгууллагад 5 олгосон. Хуулбар нийт 22	100 хувь

						<p>үүнээс: иргэн, хуулийн этгээдэд 13, төрийн байгууллагад 9 олгосон. Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой аж ахуй нэгжийн мэдээллийг жагсаалтаар төрийн байгууллагад нийт 6 удаа хүргүүлсэн. Үүнд: Санхүү, төрийн сангийн хэлтэст 1 удаа, Аймаг дахь худалдаа аж үйлдвэрийн танхимд 1 удаа, Нийгмийн даатгалын хэлтэст 2 удаа, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 1 удаа, Аймгийн онцгой комисст 1 удаа хүргүүлсэн.</p> <p>-Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр: Бүртгэлтэй холбоотой лавлагаа хуулбар 48, Хууль хяналтын байгууллагад 157 лавлагаа мэдээлэл хүргүүлэв. Эрх түдгэлзүүлсэн бүртгэл 8, сэргэсэн 4 бүртгэл бүртгэгдсэн байна.</p>	
2.4	Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг үргэлжлүүлэх, нэмэгдүүлэх	-	-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумдын тоо;	3	8	Сумдын улсын бүртгэгч нар тайлант хугацаанд буюу 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 168 мэдүүлэг хүлээн авч /газар-107, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө-76/ хуулийн хугацаанд багтаан шийдвэрлэсэн байна. 2023 онд Баацагаан, Заг, Галуут, Бөмбөгөр, Өлзийт сумын улсын бүртгэгч нарыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгох сургалтанд хамруулах асуудлыг шийдвэрлүүлэхээр	70 хувь

						Хэлтсийн даргын 2023 оны 1/325 дугаарт албан бичгийг edoc системээр ЭХЭУБГ-т уламжлан танилцуулаад байна.	
2.5	Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэхэд зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх.	-	-Мэдээлэл нийлүүлэх, авах гэрээг шинэчлэн байгуулсан нотариатчдын тоо -Нотариатаар зуучлуулан эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн бүртгэлийн тоо	0 0	3 2	Энэ ажлыг ЭХЭУБГ хариуцсан болно.	-
2.6	Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах, өөрчлөлт оруулах, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх	-	-газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сангийн өөрчлөлт оруулсан хувь - хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн хувь	0 0	10 10	Тус ажлын хүрээнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд эд хөрөнгийн хаяг өөрчлөгдсөн бүртгэл хийгдсэн нийт бүртгэлийн тоог 2019-2022 оныг хамруулсан судалгааг хийж байна. Судалгаа хэрхэн хийгдэж байгаа талаар ЭХЭУБГ-т урьдчилсан байдлаар танилцуулж, холбогдох зөвлөгөө зааврыг авсны дагуу судалгаан дээр нэгж талбарын дугаар нэмж оруулж бичих чиглэлийн дагуу судалгаагаа баяжуулж сайжруулж байна. Тайлант хугацаанд хаягийн санд эд хөрөнгийн 4 шинэ хаяг оруулсан байна. Холбогдох	50

						мэдээг сар бүр гаргаж ЭХЭУБГ-т тайлагнасан байна.	
Зорилт 3. Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.							
3.1	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	90,9	100	2023 оны Хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төлөвлөгөөт шалгалт-1, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт-3, Өргөдөл, санал, гомдлын мөрөөр хийсэн шалгалт-185, нийт хяналт шалгалт 867 байна. Хяналтын шалгалтын төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн батлан хэрэгжүүлж байгаагаас хэрэгжилт 62,5 хувьтай байна.	62,5
3.2	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг арилгах	-	-Зөрчлийг арилгасан хувь	100	100	1.Иргэний улсын бүртгэлийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн онлайн сургалтаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 100 шейр дотоод сүлжээнд байршуулсан Баянхонгор аймагт бүртгэгдсэн 668 иргэний цахим үнэмлэхний зураг тулгалтыг нэг бүрчлэн шалгаж дуусгасан. Зураг зөрүүтэй зөрчил байхгүй байсан. 2.Иргэний улсын бүртгэлийн газраас 2023 оны 04 сарын 27-ны өдөр өгсөн “Мэдээллийн сан цэгцлэх” ажлын хүрээнд “Бүртгэсэн” төлөвтэй 29 иргэний мэдээлэл ирүүлснийг бүрэн шалгаж, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах	70

						<p>8, зөрчилгүй баталгаажуулах 21 бүртгэл байгааг шалгаж ИУБГ-т хүргүүлээ. Харин 8 бүртгэлд дүгнэлт гаргуулахаар Хяналтын улсын байцаагч Л.Мэндбаярт хүсэлт өгсөн ба цахимжуулаагүй байсан хувийн хэргүүдийг бүрэн цахимжуулсан.</p> <p>Жагсаалтад холбогдох тайлбарыг хийж 100 шэйрт “ЗӨРЧИЛ 2023” дотор 2023-05-01-ний өдөр байршуулсан.</p> <p>3.Иргэний улсын бүртгэлийн газраас 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн “Бүртгэсэн”, “Алдаатай” төлөвтэй 25 иргэний мэдээллийг шалгасан. Үүнээс 23 иргэний холбогдох бүртгэлүүдэд дүгнэлт гаргуулахаар хяналтын улсын байцаагч Л.Мэндбаярт шилжүүлсэн ба өнөөдрийн байдлаар 2 иргэний бүртгэлд дүгнэлт гаргасан ба баталгаажаагүй байна. Харин 2 иргэний мэдээлэлд “Бүртгэсэн”, “Алдаатай” төлөвтэй бүртгэл байхгүй байна. Зөрчилтэй иргэдийн бүртгэлийг хяналтын улсын байцаагч Л.Мэндбаяр дүгнэлт гаргахаар ажиллаж байна.</p>	
3.3	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжүүлж ажиллах	-	-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100	100	Төлөвлөгөөг 1 зорилтын хүрээнд 5 арга хэмжээг батлан	40 хувь

						хэрэгжилтийг ханган ажиллаж хэрэгжилт 40 хувьтай байна.	
Зорилт 4. Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийх, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулна.							
4.1	Иргэний улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн баримт болон шинээр хүлээн авсан ИУБ маягтыг цахимжуулах.	-	Цахимжуулалтын хувь	100	100	Иргэний улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор Иргэний улсын бүртгэлийн цахим санд тусгагдаагүй 121 иргэний 400 орчим хуудас ИУБ маягтыг шинээр цахимжуулж санд тусгасан.	100 хувь
4.2	Аймаг, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэст хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах.	-	Цахимжуулсан иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулсан хувь	100	100	2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр төрсний бүртгэл-2884, гэрлэсний бүртгэл-823, гэрлэлт дуусгавар болсон бүртгэл-167, үрчилсэний бүртгэл-102, эцэг эх тогтоосны бүртгэл-139, овог, эцэг эх, өөрийн нэр өөрчилсөний бүртгэл-162, нас барсны бүртгэл-678, иргэний үнэмлэхний бүртгэл-1880, регистрийн дугаар өөрчлөлтийн бүртгэл 3, шилжилт хөдөлгөөн 2198, үндэсний энгийн гадаад паспорт 1466 нийт 10502 хуудас холбогдох эх нотлох баримтуудыг цахимжуулсан ба тэдгээрийг хууль журамд зааснаар бүрэн гүйцэт, шаардлага хангасан байдлаар цахимжуулсан эсэх талаар мэдээллийн сангаас шалган, баталгаажуулж ажиллалаа.	100 хувь

Зорилт 5. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.							
5.1	“Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2023”-ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	100	100	Хэлтсийн сургалтын төлөвлөгөөг хагас бүтэн жилээр батлан хэрэгжүүлдэг. Эхний хагас жилийн байдлаар хэлтсийн дотоод сургалт нийт 18 удаагийн сургалт мэдээллийн цаг орохоор төлөвлөснөөс 2 сургалт Насан туршийн боловсролын төвөөс шалтгаалан тасарсан. Хэлтсийн албан хаагчдын нэгдсэн сургалтыг мөн тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлж 3 дугаар сарын 30-31-ний өдөр зохион байгуулж ирц 97,2 хувьтай оролцлоо.	88,8 хувь
5.2	Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах хөтөлбөр, төлөвлөгөөний холбогдох заалтыг хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	75	90	“Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр” 2023 оны 05 дугаар сарын 4-ний өдөр батлагдаж ирсэн. Төлөвлөгөөг нийт албан хаагчдад уншиж танилцуулсан. Төлөвлөгөөнд туссан хэлтэст хамаарах 6 арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд 2023 оны 4-6 дугаар саруудад явган алхалт, аялал 3 удаа хийсэн, 3 сарын 30-31-ны нэгдсэн сургалтын үеэр 6 багт хуваагдаж спортын 3 төрөлт	50 хувь.

						тэмцээн зохион байгуулсан. 2023 оны 4 сарын 24-ний өдөр Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд орон сууцны хөнгөлттэй нөхцөлд хамрагдах албан хаагчдын судалгааг shinebayar.b@burtgel.gov.mn хаягаар хүргүүлсэн.	
5.3	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдах сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	-	-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо;	36	36	УБЕГ-аас өгсөн үүргийн дагуу албан хаагчдыг тус системд өөрт холбогдох салбарын хичээлийг судалж дуусгахыг мэдэгдсэнээр эхний улирлын байдлаар 90 хувьтай, хагас жилийн хугацаанд бүрэн судлах үүргийг өгсөн дагуу хэрэгжилтийг гаргахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэж байна. Системд бүртгэл орсон боловч хичээл нь нээгдэхгүй байгаа нэг албан хаагчийн мэдээллийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Нийт 36 албан хаагч ажиллахаас зарлуулаад томилогдоогүй 2 сум, чөлөөлөгдсөн 1 албан хаагч байгааг хасаад хамрагдах ёстой 33 албан хаагчаас хамрагдаж судалсанг тооцвол 28 албан хаагч байна.	84,8
5.4	Аймгийн бүх иргэдийг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах зорилтот хөтөлбөрт бүх албан хаагчдыг	-	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг	60	100	Өмнөх оны жилийн эцсийн байдлаар хамрагдалт 60 хувьтай байсан бол он гарч үзлэг оношлогоонд хамрагдалт 8 –аар нэмэгдэж, сумдын улсын	78.9

	хамруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах		шинжилгээнд хамруулсан хувь			бүртгэгчид сумын ЗДТГ-ын хамт олонтойгоо үзлэг оношлогоонд хамрагдсан байна.	
5.5	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх	-	Хүргүүлсэн тоо	12	12	Иргэн, Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн бүртгэлийн тоон мэдээ, лавлагааны мэдээ, үнэт цаасны, хяналтын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тоон мэдээ зэргийг 2023 оны эхний хагас жилд 5 удаа хугацаанд нь хүргүүлсэн болно.	100
Зорилт 6. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах							
6.1.	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих	-	-Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь;	91,04	100	Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу байгууллагад ирсэн өргөдлийг бүртгэлжүүлэн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар нийт 68 өргөдөл ирсэн. Үүнээс бүрэн шийдвэрлэсэн 63, шийдвэрлэх шатандаа 5 өргөдөл байна. Өргөдөл гомдлын мэдээ, тайлан үнэн зөв гарган улирал тутам аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст мөн УБЕГ-ын b.tuul@burtgel.gov.mn хаягаар хүргүүлэн ажиллаж байна.	
6.2	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих	-	-Хугацаатай хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь;	100	100	Хэлтсийн хэмжээнд 2023 оны 06 дугаар сарын 06-ны байдлаар ирсэн албан бичиг 413, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаал, чиглэл, зөвлөмж, дотоод албан бичиг	100

						<p>нийт 42 тус тус бүртгэгдсэн байх ба хэлтсээс 435 албан бичиг явуулсан байна.</p> <p>Ирсэн, явсан албан бичиг болон өргөдөл, гомдлыг скайнердэж Able, erp.e-mongolia.mn программ дээр бүртгэн хяналтын карт хөтлөн хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Хэлтэст нийт 256 хариутай албан бичиг ирүүлсэн ба хуулийн хугацаа хэтрүүлэн хариу илгээсэн албан бичиг байхгүй 100 хувь шийдвэрлэсэн болно.</p>	
6.3	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих	-	-Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь;	90	100	<p>Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажиллахыг анхааруулж байнгын хяналт тавин ажиллаж байна. Ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар ямар нэгэн зөрчил илрээгүй, гомдол мэдээлэл ирээгүй байна. Үйлчилгээний стандарт мөрдөлтийн явцын талаар сар бүрээр нэгтгэж хамт олны мэдээллийн цагт 5 удаа танилцуулж хэрэгжүүлэхийг үүрэг болгон ажиллаж байна. Үйлчилгээний стандартын хэрэгжилтийг тооцож үзэхэд 90 хувьтай байна.</p>	90

6.4	УБЕГ-ын Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын бүртгэл хөтөлж, хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	72,2	100	УБЕГ-ын даргын шуурхай цахим хуралд 6 удаа, Тамгын газрын даргын шуурхай хурлын мэдээлэл хүргэх цахим хуралд 12 удаа тус тус оролцож үүрэг даалгаврыг авч албан хаагчдад мэдээлэл хүргэн хэрэгжүүлж ажиллаж байна.	
6.5	Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах	-	Нууц баталгаа авсан хувь	100	100	2023 оны гарсаар хэлтсийн нийт албан хаагчдаас гүйцэтгэж буй ажил үйлчилгээтэй холбоотойгоор нууцын баталгааг нийт 37 албан хаагчаас гаргуулан авсан, мөн нөхөн сонгуультай холбоотойгоор Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар томилогдон ажиллаж буй нийт 9 албан хаагчаас нууцын баталгааг гаргуулан авсан. Аймаг дахь Тагнуулын хэлтэст 2022 оны нууцын ажлын тайланг хугацаанд нь гарган хүргүүлсэн. 2023 оны 4 сард шинээр томилогдсон 1, чөлөөлөгдсөн 1 албан хаагчаас нууцын баталгааг гаргуулан авч хууль тогтоомжийг тайлбарлан таниулж уншиж судлах үүргийг өгсөн болно.	100 хувь

6.6	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх	-	Сар бүрийн тоон мэдээг байршуулсан тоо	12	12	Улсын бүртгэлийн ерөнхий газарт сар бүрийн тоон мэдээг тухай бүр нь үнэн зөв гаргаж хугацаанд нь хүргүүлж нэгтгүүлсэн. Мөн Хэлтсийн bayankhongor.burtgel.gov.mn вэйб хаягийн сар бүрийн тоо мэдээ цэст болон хэлтсийн мэдээллийн самбарт 5 удаа байршуулсан болно.	100 хувь
6.7	Байгууллагын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, телевиз радиогийн нэвтрүүлэгт оролцох	-	-Сурталчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрлийн тоо; -Олон нийтэд сурталчилсан мэдээ, мэдээллийн тоо;	3 361	3 400	-2023 оны эхний хагас жилийн хэлтсийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг https://bayankhongor.burtgel.gov.mn/ сайт болон байгууллагын facebook page хуудсуудаар дамжуулан иргэдэд түгээж байна. Мөн бүртгэлүүдийн талаар шинэ гарын авлага, болон шинэ мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. 2023 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар https://bayankhongor.burtgel.gov.mn/ сайтад 21 удаагийн мэдээ мэдээлэл, Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс facebook page хуудсанд 121 удаагийн мэдээлэл тавьж ажилласан байна. УБЕГ болон хэлтсийн facebook page хуудаст байршуулан мэдээ мэдээллийг нийт 38 албан хаагчдыг тухай бүр нь лайк, шэйр хийж байхыг үүрэг болгон гүйцэтгэлийн	3 142

						<p>төлөвлөгөөнд тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>- Үндэсний энгийн болон цахим гадаад паспорт олголтын талаар Аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн алба болон орон нутгийн Номгон TV-ээр мэдээлэл өгч олон нийтэд цацуулсан нэвтрүүлгийг хийлгэсэн.</p>	
6.8	Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулах	-	“Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулсан тоо;	5	3	<p>“Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Баянхонгор сумын Шаргалжуут 8 багт зохион байгуулж Улсын бүртгэгч Г.Бадамханд 146, Б.Өлзийбаяр 411 бүртгэл, мөн Баянхонгор аймгийн Хүрээмарал суманд зохион байгуулж Тоон гарын үсэг-322, иргэний үнэмлэх шинээр авсан-1, 25,45 насны сунгалт-7, иргэний үнэмлэх олголт-6, иргэний үнэмлэх дахин авсан-2, гадаад паспорт-21, эд хөрөнгийн бүртгэл-2 нийт 361 бүртгэл тус тус бүртгэсэн.</p>	33,3 хувь
6.9	Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах	Орон нутгийн төсөв	Санал тавьж шийдвэрлүүлсэн тоо	2	1	<p>Албан хаагчдын нэгдсэн сургалт семинарийн 2 хоногийн арга хэмжээнд орон нутгийн өмчит компаниудад хүсэлт тавьж цайны цаг, үдийн цай хоол, тэмцээн уралдааны зардалд дэмжлэгийг авсан болно.Баянхонгор сумын Засаг даргад хэлтсийн албан</p>	50 хувь.

						хаагчдад газар олгох хүсэлтийг дахин хүргүүлсэн.	
6.10	Байгууллагын тусгай төрлийн баримтыг Төрийн архивт шилжүүлэх	-	Баримтыг заасан хугацаанд бүрэн шилжүүлсэн баримтын тоо	39	30	Хугацаа болоогүй.	-
Зорилт 7. Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.							
7.1	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах		Зөрчлийн тоо Зөвлөмжийн тоо Албан шаардлагын тоо Акт	0 0 1 1	0 0 0 0	Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 оны 06 дугаар сарын 06-ны байдлаар улсын төсвөөс 303.178.6 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч цалин хөлсний зардалд 1238.183,3, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 30.370.4, гэрэл цахилгааны зардалд 959,0, түлш халаалтын зардалд 21.128,4 цэвэр бохир усны зардалд 702,2, бичиг хэргийн зардалд 4.298.0, тээвэр шатахууны зардалд 625,0, шуудан холбооны зардалд 610.1, хог хаягдал зайлуулах зардалд 150.0, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 1.040.0, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 180.0, урсгал засварын зардалд 604.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 308.0, нэг удаагийн тэтгэмж	100 хувь

						урамшууллын зардалд 100,0, улсын төсвийн орлогын дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 89.407.7 мянган төгрөг төвлөрүүлэн ажиллалаа. Төрийн Аудитын байгууллагаас “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан болно.	
7.2	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах	-	-Байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо; -Хугацаанд аа байршуулсан хувь	144 100	144 100	Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn , сайтад сар бүр тогтмол байршуулан 68 удаагийн мэдээлэл шинэчилж, www.bayankhongorburtgel.com сайтад тогтмол байршуулан 5 удаагийн мэдээлэл шинэчилж байршуулсан байна.	100
7.3	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг болон дараа жилийн зорилтыг хангахуйц төсвийг төлөвлөх, хүргүүлэх, батлуулах		Хүргүүлсэн хувь	100	100	2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг боловсруулж хугацаанд нь хүргүүлсэн боловч шинэ системд шивэх үүрэг өгсөн шивэгдэж байна.	100

